СҮХБААТАР НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.11.07

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | 2.3.Эрүүл монгол хүн<br>**Зорилт 2: Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | |
| 2 | 2.1.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, | Зонхилон тохиолдох өвчний эрсдэлт хүчин зүйлсийг тандах урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх | Хамрагдах хүний тоо - 13142<br>Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо<br>Эрт илрүүлгийн хувь -10% | Хамрагдах хүний тоо сард -250-400 Сурталчил-гааны ма-териалын тоо 1500 Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ | Гүйцэтгэлийн санхүүжилт | 2025 эхний 10 сарын гүйцэтгэлээр харьяат хороодоос 36 хүн эрт илрүүлэгт орсон.<br>2025 онд<br>• 42468 хүнийг үзлэг оношилгоонд хамруулсан. Үүнээс:<br>• Цэцэрлэг – 50<br>• Сургууль – 8 нийт 30632 хүн, үүнээс хүүхэд 29148, багш ажилчид 1534,<br>• ахмадын үзлэгт – 380 хүн,<br>• Байгууллага – 8, 348 ажилтан болон амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээнд 11108 хүнийг 2025 оны 10 сарын 30-ны байдлаар хамруулаад байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ | | | | | Үзлэгээр илэрсэн эмгэгийн талаар өрхийн эмч нарт мэдээлж, хяналтанд авахыг зөвлөж ажиллав. | |
| 3 | 2.1.2 Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Нэр төрлийн тоо үйлчилгээний тоо<br>Хамрагдсан хүний тоо | Нэр төрлийн тоо 9<br>Үйлчилгээний тоо 9<br>Хамрагдсан хүний тоо 26307 | Гүйцэтгэлийн санхүүжилт | Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийг 24 цагаар үзүүлдэг бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хանган ажиллаж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Нэгдсэн эмнэлэгт 12944 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн.<br>Яаралтай тусламжийн нэгжээр үйлчлүүлсэн хүний тоо – 25954 байна. Яаралтай тусламжийн хуудсаар эмчилгээ хийлгэж зөвлөгөө авч буцсан 20340 байна. Үүнээс хүүхэд 12590, насанд хүрэгчид 7750.<br>Эмзэг бүлгийн 67 иргэнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч 1856 хэвтэн эмчлүүлсэн байна.<br>Хүүхдийн эрчимт эмчилгээнд 216, насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээнд 520 хүнд амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ үзүүллээ. | 100 |
| 4 | 2.1.4 Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног | Яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах | Тоног төхөөрөмжийн тоо<br>Хэрэгжилтийн хувь | Тоног төхөөрөмжийн хангалт | Гүйцэтгэлийн санхүүжилт | Яаралтай тусламжийн тасагт 2025 онд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж ажиллаж байна. Байвал зохих тоног төхөөрөмжийн хангалт 95% байна.<br>Эмнэлгийн зориулалтын бүрэн тоноглогдсон 2 автомашинтай.<br>Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжинд амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн ханаины дамжуулах систем, тарианы шахуургууд, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмжөөр хангана. | | | | | өвчтөний хяналтын монитор, дефибриллятор, хүчил шүлтийн үзүүлэлт тодорхойлох аппарат, зөөврийн рентген аппарат, зөөврийн эхо аппарат, зөөврийн хүчилтөрөгчийн баллон, цахилгаан соруулга, угаарын хий хэмжигч, яаралтай үеийн эм тарианы нөөцийн хангалтыг бүрдүүлэн ажиллаж байна. Яаралтай тусламжийн оношилгоонд нэн чухал хэрэглэгдэх компьютер томографийн аппараттай. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн баг ажилладаг. Хурц үеийн диализийн тусламж үйлчилгээг бүрэн үзүүлдэг. | |
| 5 | 2.1.6 Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | Алсын зайн оношлогоо эмчилгээг өргөжүүлэх | Холбогдсон эмнэлгийн тоо, эмчийн тоо, өвчтөний тоо | | Гүйцэтгэлийн санхүүжилт | Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн "Аксис карте" цахим системийг суурилуулан хөгжүүлэлт хийн ажиллаж байна. Өвчний түүхийг цахим байдлаар хөтөлж, ЭМДЕГ, НД –тай цахимаар холбогдож ажил хэргээ явуулж байна.<br><br>Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 6 | 2.1.7 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, | Гүйцэтгэлийн санхүүжилтийг | Гүйцэтгэлийн санхүүжилтийн хувь | 350 орчим ОХБ-ээр | ЭМДЕГ-тай гэрээ | ЭМДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн дагуу гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна. | оновчтой нэвтрүүлэх | | санхүүжилт авч байна. | байгуулсан. | | |
| Зорилт 4: Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ<br><br>4.1 Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ. | | | | | | | |
| 7 | 4.1.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана | Эрхэм зорилго, үйл ажил-лагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуу-лалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байр- | Мэдээллийн нэр төрөл, мэдээллийн тоо, хандалтын тоо<br><br>Хэрэгжилтийн хувь | Вэб сайт 68 мэдээлэл, мэдээллийн самбарт 11 мэдээлэл тавьсан. | Гүйцэтгэлийн санхүүжилт | Байгууллагын эрхэм, зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийн талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Байгууллагын вэб сайтад 37 чиглэлээр 68 мэдээлэл байршуулсан.<br><br>Тасгуудын сургалтын самбарт, ТТТӨ, Эрт илрүүлэг оношилгооны багц ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу шинээр хэрэгжих журам заавруud зэрэг үйлчлүүлэгчдэд зориулсан нийт 62 мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн сурталчиллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | луулан тухай бүр шинэчлэх | | | |     | |
| 8 | 4.1.10.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна. | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтийг хангах | Хэрэгжилтийн хувь<br>Мэдээлийн сан<br>Эмч ажилчдын тоо | Цалингийн нэгдсэн мэдээллийн санд 259 эмч ажилчдын мэдээллийг оруулж 5 удаа төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бодож олгосон. | | Төрийн албаны цалингийн нэгдсэн мэдээллийн санг хүний нөөцийн цахим системтэй холбож 286 эмч ажилчдын мэдээллийг оруулж 2025 онд цалинг нэгдсэн системээр бодож олгож байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 4.1.11 Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүнд өвчтөний хяналтыг сайжруулах зорилгоор камерийн системийг өргөжүүлэх | Камерийн тоо<br>Хуулбарласан бичлэгийн тоо | Камер 30 ш<br>Бичигч1 ш<br>Хуулбарласан тохиолдол 10 удаа | Гүйцэтгэлийн санхүүжилт | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай газруудад 8 ширхэг камерыг нэмэлтээр байршуулсан. Нийт 30 цэгт 24 цагийн камерийн хяналтын системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Дотоодын хяналт сайжирсан. | 100 |

Дүгнэлт: Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан 8 заалттай ажлын хэрэгжилт 99.7%-ийн гүйцэтгэлтэй байна

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ ДАРГА Ч.АРИУНАА

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ДАРГА Б.БАТЧИМЭГ